



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER


f facebook.com/Rtcc.m0n
globe http://rtcc.mrtd.gov.mn
envelope info@rtcc.mrtd.gov.mn
phone +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2020 оны 05 дүгээр сарын дугаар

Ажлын хэсэг


“ГТХЗНТ” УТУГ нь Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох ажлыг хариуцан ажиллахаар боллоо.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 04-р сарын 21-ний өдрийн А/81 тоот тушаалаар Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгохтой холбоотой зарим эрх үүргийг гэрээний үндсэн дээр “ГТХЗНТ” УТУГ-т шилжүүлэхээр болсон.





ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТой ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЧИЛГЭЭ






Гэрчилгээ олгох журмын зорилго

-  Салбарын тасралтгүй, найдвартай, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх хөдөлгөөний аюулгүй байдал болон үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх
-  Тээх, нэвтрүүлэх чадвар болон өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлох
-  Салбарт дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх

Гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаа

- ✓ Гэрчилгээ бүхий объект, үйл ажиллагаа нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсхийг хянан шалгах, гэрчилгээ олгох, нутадаг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох;
- ✓ Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх

Баримтлах зарчим

-  Хууль тогтоомж
-  Дэрэм журмын
-  MNS 5523:2013

Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа

- Ил тод, нээлттэй,
- Шуурхай, хүргэмжтэй,
- Чанартай, аюулгүй байдалыг хангасан

Гэрчилгээжүүлэлтийн төрөл:

- Даргасан хэрэглээний замын дээд доод бүтцийн захир, арчлалт гүйцэтгэх;
- Төмөр замын зураг төсөл боловсруулах;
- Даргасан хэрэглээний зам, талбай барих;
- Даргасан хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх;
- Төмөр замын дохиолол, холбооны байгууламжийн техникийн үзэл, үйлчилгээ гүйцэтгэх;
- Зүүтүүрийн техникийн үзэл, үйлчилгээ гүйцэтгэх;
- Вагоны техникийн үзэл, үйлчилгээ гүйцэтгэх;
- Төмөр замын тээвэр рүүчлалын үйл ажиллагаа эрхлэх;
- Хатуу тосгоорт багаж, хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх;



Дараах объектуудыг гэрчилгээжүүлэх:

- Суурь бүтэц, ашиглах чиглэлээр:
- Нийтийн хэрэглээний зам, талбай;
- Даргасан хэрэглээний зам, талбай;
- Өртөн, зарлаг /төмөр замын дохиолол, холбооны байгууламж/


Хөдлөх бүрдэлдхүүний чиглэлээр:

- Бүх төрлийн зүтгүүр;
- Бүх төрлийн ачааны вагон;
- Бүх төрлийн зорчигчийн вагон;
- Сэргээн босгох, гал унтраах галт тэрэг;
- Зам засвар, арчлалт, оношлогоо, хэмжил хийх бүх төрлийн машин механизм;

Гэрчилгээний загвар





Объект, үйл ажиллагааны гэрчилгээ хүсэгчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх дараалал



Сайдын тушаалын дагуу “Зам, тээврийн хөгжлийн яам” нь уг гэрээг 2020 оны 05-р сарын 27-ны өдөр “ГТХЗНТ” УТУГ-тай 6 сарын хугацаатай байгууллаа. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 05-р сарын 19-ны өдрийн А/73 тоот тушаалаар эрх үүрэг шилжүүлэхтэй холбогдуулан байгуулагдсан ажлын хэсэг ажил хүлээлцэв.

2020 оны 05-р сарын 26-ны өдрөөр хүсэлт гаргасан тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн бичиг баримтыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар олгон 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс уг үйл ажиллагааг “ГТХЗНТ” УТУГ хэрэгжүүлэн ажиллахаар боллоо.





"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу 2020 оны 04 дүгээр сарын төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.

2020 оны 04 дүгээр сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtcc.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.



Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дахин хянаж нэмэлт, өөрчлөлт оруулж, танилцууллаа.



Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дахин хянаж нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 360 дугаар ажлын хэсгээс боловсруулсан 18 журмын төсөлд тусгахаар "УБТЗ" ХНН,



"ГТХЗНТ" УТҮГ, ЗТХЯ-ны ХШҮДАГ, "МТЗ" ТӨХК, ДНЧ-3 -аас албан бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлсэн 477 саналын нэгдсэн товьёо боловсруулж ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т хүргэж танилцуулав.

"ГТХЗНТ" УТҮГ-ын үндсэн үйл ажиллагаатай холбоотой Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам, Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам, Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмын ерөнхий мэдээллийг 9 үзүүлэлтээр, захиргааны хэм хэмжээний актад тавих шаардлагад нийцэж байгаа эсэхийг 10 үзүүлэлтээр, дүгнэлт саналыг 3 үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж "ГТХЗНТ" УТҮГ-т зохион байгуулагдсан төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн хэлэлцүүлэгт холбогдох саналыг танилцуулав.


2020 оны 4 дүгээр сард өссөн дүнгээр 556.14 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -27.7%-аар буурсан, 9510.21 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 11.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2020 оны дөрөвдүгээр сард 107.5 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2395.7 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Ачилт- ачааны төрлөөр /2020 оны 4 дүгээр сард/



Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2020 оны дөрөвдүгээр сард 348.9 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.

Ачилтаар 2020 оны дөрөвдүгээр сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1778.1 мян.тн ачсан байна.





Суурь бүтцийн 2020 оны 4-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

2020 оны 4-р сард нийтдээ 88 удаагийн зурмагын тасалдал бүртгэгдсэнээс:



Зүтгүүрийн албаны 2020 оны 4-р сарын тасалдлыг өмнөх сартай харьцуулахад үзэхэд энэ сард 21 нэгж буюу **19.26%**-иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалтыг өмнөх сартай харьцуулахад энэ сард 7 нэгж буюу **77.78%**-иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалт 4 дүгээр сар

| д/д | Өргөөний нэр | Галт тэрэгний тоо | | |
|------|--------------|-------------------|---------|-----------|
| | | төлөвлөсөн | биелсэн | тасалдсан |
| 1 | Сүхбаатар | 54 | 53 | 1 |
| 2 | Дархан | 81 | 81 | 0 |
| 3 | Шарын гол | 54 | 54 | 0 |
| 4 | Эрдэнэт | 27 | 27 | 0 |
| 5 | Зүүнхараа | 27 | 27 | 0 |
| 6 | Улаанбаатар | 110 | 109 | 1 |
| 7 | Айраг | 7 | 7 | 0 |
| 8 | Бор-Өндөр | 7 | 7 | 0 |
| 9 | Сайншанд | 0 | 0 | 0 |
| 10 | Замын-Үүд | 29 | 29 | 0 |
| Бүгд | | 396 | 394 | 2 |



Суурь бүтцийн 2020 оны 4-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан



Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх сартай харьцуулан үзэхэд энэ сард 8 нэгж буюу **66.67%** -иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлт 4 дүгээр сар

| д/д | Өргөөний нэр | Галт тэрэгний тоо | | |
|------|-------------------------|-------------------|---------|-----------|
| | | төлөвлөсөн | биелсэн | тасалдсан |
| 1 | Сүхбаатар – Улаанбаатар | 107 | 104 | 3 |
| 2 | Дархан – Улаанбаатар | 0 | 0 | 0 |
| 3 | Дархан – Шарын гол | 108 | 108 | 0 |
| 4 | Дархан – Эрдэнэт | 54 | 53 | 1 |
| 5 | Зүүнхараа – Улаанбаатар | 54 | 54 | 0 |
| 6 | Айраг – Бор-Өндөр | 14 | 14 | 0 |
| 7 | Улаанбаатар - Сайншанд | 0 | 0 | 0 |
| 8 | Улаанбаатар – Замын-Үүд | 58 | 58 | 0 |
| Бүгд | | 395 | 391 | 4 |

Ачааны галт тэрэгний явуулалтыг өмнөх сартай харьцуулан үзэхэд энэ сард 2 нэгж буюу **18.18%** -иар өссөн үзүүлэлттэй байна.






Суурь бүтцийн 2020 оны 4-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх сартай харьцуулан үзэхэд тасалдлын тоо 8 нэгж буюу **10.12%** -иар буурсан үзүүлэлттэй байна.



Нийт 88 тасалдал бүтгэгдсэний 64.77 хувь (57 тасалдал) нь зүтгүүрийн гэмтлээс үүдсэн тасалдал бүртгэгдсэн байна.

Зүтгүүртэй холбоотой 57 тасалдалын 32 (56.14 хувь) нэгжийг 2ТЭ116УМ серийн зүтгүүр, 7 (12.28 хувь) нэгжийг 23АГАЛ серийн зүтгүүр, 6 (10.52 хувь) нэгжийг 2ТЭ25КМ болон 2ТЭ116УД серийн зүтгүүрүүд нь тус тус эзэлж байна.



Нийтдээ хохирлын хэмжээ 22'298'456₮ болсон байна. Үүнээс зүтгүүрийн гэмтлээс үүдэлтэй саатсан хохирлын хэмжээ 13'892'214 (62.30%) төгрөг, хоорондын замд саатсан галт тэргийг хүлээн зогсож зурмагаас гарсан тасалдлын хохирлын хэмжээ 6'572'648 (29.48%) төгрөг эзэлж байна.

Мөн технологийн зөрчил буюу ажилчдын буруутай үйлдлээс үүдсэн тасалдлын хохирлын хэмжээ 736'727 (3.30%) төгрөг, бусад шалтгаантай (төмөр замын гарам, төмөр зам дээр хүн, машин, мал байсан болон дайрагдсан) тасалдлын хохирлын хэмжээ 641'646 (2.88%) төгрөг, бүхээгний аюулгүй байдлын систем (БАБС) -ийн доголдлоос үүссэн тасалдлын хохирлын хэмжээ 455'221 (2.04%) төгрөг болж тус тус эзэлж байна.



2019 онд Октябрскийн төмөр зам нь төмөр замын гарц, дэд бүтцийн төхөөрөмжийг сэргээн засварлах, хөдлөх бүрэлдэхүүний паркийн шинэчлэл, нөөц хэмнэх технологийг нэвтрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, зорчигчдод үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг томоохон хөрөнгө оруулалтын ажлыг хийхээр төлөвлөн эхлүүлсэн.

Хамгийн чухал хөрөнгө оруулалтын төсөл нь "Мга-Сонково-Дмитров чиглэлийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор хоёр дахь замыг барих юм. Энэ чиглэл нь гурван мужийн нутаг дэвсгэрээр дамждаг 592.3 км урттай нэг замтай шугам бөгөөд баруун хойд бүс, Финландын булангийн боомтуудыг Оросын төв ба зүүн бүс нутгуудтай холбодог.




Одоогийн байдлаар зураг төсөл, судалгааны ажил хийгдэж, Мга-Кириши хэсгийн төмөр замыг бүрэн цахилгаанжуулсан. Пестово-Овинице хэсгийг автомат хаалтаар тоногловон, Мга өртөөн дээр хаалт, төмөр замын гарц барих ажил хийгдсэн. Мга-Савелово хэсгийн дамжуулах хүчин чадлыг өдөрт 14 хос ачааны галт тэрэг болгож, орон нутгийн төмөр замын хурдыг нэмэгдүүлсэн.





ОХУ: Октябрскийн төмөр зам

Октябрскийн төмөр замын тэргүүлэх хөрөнгө оруулалтын төсөл нь Мга-Гатчина-Веймарн-Иванг ород хэсгийг иж бүрэн шинэчлэх, Финландын булангийн өмнөд эрэг дээрх боомтуудын төмөр замыг шинэчлэх явдал юм.




Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ачааны бүрэн бүтэн байдлыг хангах, ашиглалтын зардлыг бууруулах зорилготой шинэлэг технологиудыг нэвтрүүлж байна. Ж и ш э э л б э л , Лужская-Сортировочная өртөөн дэх сэлгээний зүтгүүрийн хяналтын систем нь машинчийн оролцоогүйгээр хэдэн жилийн турш амжилттай ажиллаж байна.

2019 онд радара болон лидараг ашиглан машинаар хайх технологи дээр суурилсан саад тотгорыг илрүүлэх орчин үеийн төхөөрөмжийг нэвтрүүлсэн. Ийм техникийн шийдлүүд нь зам дээрх хөдлөх бүрэлдэхүүнийг таньж тэдгээрийг ангилж тодорхойлох боломжийг олгодог.



Ялгах парк дахь довын автоматжуулсан төвлөрүүлэлтийн барилгын удирдах пульт болон гар удирдлагатай зөөврийн төхөөрөмжийн аль алинаас нь сэлгээний зүтгүүрийг алсын удирдлагаар хангах сэлгээний зүтгүүрийн алсын удирдлагын системийг туршилт хийж, ашиглаж байна.



 **8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс**

